



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 31-26 42 30
E-mail: info@audit.gov.mn

2022. 03. 15 № 07/574

танийн № -т

Г Хараат бус аудиторын тайллан

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Х.АЛТАЙ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, ёмчийн вөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайллан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлапгын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв төлилүүлсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиостой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолжон зүйл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 5,520.9 сая төгрөг болж төлөвлөсөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.5 хувиар давсан нь тайлант онд үнэт цаасны арилжааны дүн өмнөх онуудаас огном всч 1.4 их наяд төгрөгт хүрсэн, бүтээгдэхүүний нэр төрөл 9-р нэмэгдсэн зэрэг компанийн үйл ажиллагааны өсөлт, банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө өруулалт хийх иргэдийн сонирхол нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нэлааётэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны орлогыг 2,738.8 сая, зардлыг 2,719.7 сая төгрөг байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 5,520.9 сая төгрөгийн орлого бурдүүлж, 2,168.2 сая төгрөгийн зардал гарч 3,352.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

W10.10.10.20/Bichig_Kherieg/Yawsan_Bichig/2022/0315_Auditin_2_Gazar - 56.Docs

001050920

Орлого төлөвлөгөөнөс 2,782.1 сая төгрөг буюу 101.6 хувиар давж биелсэн байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хулаэнэ.

Байгууллагын жилийн тайланд З зорилтын хурзанд 17 арга хэмжээг хэрэгжүүлжээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл нь байгууллагын жилийн тайландаа орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл тухайлбал, биржийн голлох үзүүлэлтийн өөрчлөлт, зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжаа, Тог 20 индекс, шинэ бутзэгдэхүүн үйлчилгээ, үнэт цаасны данстай иргэдийн тоо, өдөрт арилжаанд оролцогчдын тоо, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэх мэт санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хулээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох буртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагнапын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах уурагтэй.

Санхүүгийн тайланг запилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үсэн дотоод хяналтыг тодорхойлж, харгажуулэх үүргээ хариуцлага хулзэнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага заллан эсвэл алдааны улмаас үүсэх материалаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бухэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсан аудитаар материаллаг буруу илэрхийлэл бурийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлзэд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нэлвэлх үндэслэлтэй байвал материаллаг гэж уздаг

АУДИТЫН ХӨЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В.М. Ц.НААНЧИМЭГ